



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/287/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:Б.Лхагвацэнд Утас:260512 Цахим хаяг:lkhagvatsendb@audit.gov.mn Аудитор: Ч.Дашдаваа Утас:261740 Цахим хаяг:dashdavaach@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал:П.Шаравхорол Утас:88472789 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 116 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Э.НҮРЗЭД ТАНАА

2024.02.29 № 07/456
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, цалин бодоходоо ажилласан жилийн нэмэгдэл болон цалингийн зэрэглэлийг илүү тооцож олгосон, баталсан бүтэц орон тооноос илүү орон тоогоор ажиллаж Нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татварын өр төлбөр үүсгэсэн зэргээс нийт 44,360.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 18,226.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтууд болон Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолд заасныг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь харааны бэрхшээлтэй сурагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалт эрхлэх чиг үүрэг хэрэгжүүлдэг. Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамнаас 2020 онд 5 жилийн хугацаатай авч, чиг үүргийн дагуу сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Тайлант оны байдлаар сургалт эрхлэх нөхцөл шаардлагад мэргэжлийн зэрэг, багшлах эрхтэй багшийн тоо 41, 1-12 дугаар ангийн 23 бүлэг, 131 харааны бэрхшээлтэй сурагчид суралцаж байна.

2023 онд Боловсролын ерөнхий хууль батлагдан хэрэгжиж, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар боловсролын байгууллагын багш, ажилчдын үндсэн цалин, 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар тусгай сургуулийн багш, туслах багш, дотуур байрны багш нарын үндсэн цалин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 19,514.6 мянган төгрөгийн орлогыг Нийслэлийн боловсролын газраас “Байгалийн ухааны цахим хөтөлбөр” төслийн төлбөрт 6,585.0 мянган төгрөг, Хүүхэд хөгжлийн газраас спортын наадмын шагналд 500.0 мянган төгрөг, Ашид мөнх тод ХХК-аас Брайл цаасны үнэд 8,563.7 мянган төгрөг, Нийслэлийн шүүхийн шийдвэр гаргах газраас шүүхийн шийдвэр гүйцэтгүүлсний орлого 3,865.9 мянган төгрөг тус тус төвлөрүүлж, холбогдох зардлуудад зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 99.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ATA9693 9006109
9023030583

Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,015,410.67	89,978,058.07
34	УРЬДЧИЛГАА	1,150,000.00	-
34700	Бусад урьдчилгаа	1,150,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	94,865,410.67	89,978,058.07
35100	Түүхий эд материал	25,545,915.91	25,894,492.31
35110	Тусгай зориулалтын материал	22,547,562.91	22,840,262.91
35130	Эм боох материал	2,998,353.00	3,054,229.40
35400	Хангамжийн материал	69,319,494.76	64,083,565.76
35410	Бичиг хэргийн материал	8,968,835.35	7,183,703.31
35420	Аж ахуйн материал	39,011,197.85	36,183,278.85
35440	Түлш шатах тослох материал	261,670.00	-
35450	Барилгын засварын материал	4,631,450.00	93,900.00
35460	Хүнсний материал	7,221,017.16	11,924,610.60
35470	Бусад хангамжийн материал	9,236,514.40	8,698,073.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,024,104,084.26	1,956,702,688.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,024,104,084.26	1,956,702,688.13
392	Биет хөрөнгө	2,020,315,520.40	1,954,614,021.95
39201	Барилга, байгууламж	1,821,494,460.66	1,821,494,460.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(292,345,521.06)	(367,687,624.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227,015,468.00	227,015,468.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(157,380,353.08)	(178,806,542.20)
39205	Машин тоног төхөөрөмж	598,014,537.07	693,905,137.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(447,702,735.45)	(506,279,075.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,458,498.20	163,208,498.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(119,854,073.60)	(127,641,906.06)
39217	Номын фонд	228,615,239.66	229,405,605.86
393	Биет бус хөрөнгө	3,788,563.86	2,088,666.18
39301	Программ хангамж	7,935,188.00	7,935,188.00
39302	Хасагдуулга	(4,146,624.14)	(5,846,521.82)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,120,119,494.93	2,046,680,746.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,255,454.59	40,078,344.39
41	Богино хугацаат өр төлбөр	15,255,454.59	40,078,344.39
41300	Өглөг	15,255,454.59	40,078,344.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,457,843.59	35,487,074.39
41312	НДШ-ийн өглөг	-	3,744,964.00
41313	ХХОАТ-ын өглөг	9,457,843.59	31,742,110.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,535,111.00	4,347,270.00
413202	Гэрэл цахилгааны өглөг	5,535,511.00	219,960.00
413203	Түлш халаалтын өглөг	-	3,847,128.00
413205	Тээвэр, шатахууны өглөг	-	280,182.00
41360	Бусад өглөг	262,500.00	244,000.00
41321	Байгууллагад төлөх өглөг	262,500.00	244,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,104,864,040.34	2,006,602,401.81

51	Засгийн газрын хувь оролцоо	2,104,864,040.34	2,006,602,401.81
51	Засгийн газрын оруулсан капитал	888,053,349.02	888,053,349.02
512	Хуримтлагдсан үр дүн	(381,212,655.56)	(479,474,294.09)
51210	Өмнөх үеийн үр дүн	(345,932,626.54)	(375,916,039.93)
51220	Тайлант үеийн үр дүн	(35,280,029.02)	(103,558,254.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,598,023,346.88	1,598,023,346.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,120,119,494.93	2,046,680,746.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,787,356,424.00	2,054,030,302.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,083,124.00	57,920,966.20
1200	Нийтлэг татварын бус орлого	48,083,124.00	57,920,966.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	24,040,781.00	53,366,966.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	24,042,343.00	4,554,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,739,273,300.00	1,996,109,335.96
1310	Улсын төсвөөс	1,738,133,300.00	1,976,594,700.00
131006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,738,133,300.00	1,976,594,700.00
1311	Нэмэлт санхүүжилт	240,000.00	19,514,635.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,563,725.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	6,585,000.00
131105	Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00	4,365,910.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	900,000.00	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ аймаг, нийслэлээс авсан санхүүжилт дэмжлэг/	900,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,822,636,453.02	2,157,588,556.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,822,636,453.02	2,157,588,556.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,699,543,396.13	2,103,142,560.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,194,863,917.33	1,558,929,910.39
210101	Үндсэн цалин	658,714,588.32	783,667,381.80
210102	Нэмэгдэл	506,014,274.91	590,650,599.59
210103	Унаа хоолны нэмэгдэл	6,046,936.16	57,758,772.50
210104	Урамшуулал	24,088,117.94	126,853,156.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,864,800.00	168,680,320.41
210201	Тэтгэврийн даатгал	147,780,600.00	116,494,520.41
210202	Тэтгэмжийн даатгал	9,021,000.00	13,046,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,216,900.00	10,437,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,102,700.00	2,609,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,743,600.00	26,092,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,441,810.60	64,621,877.00
210301	Гэрэл, цахилгаан	16,752,060.00	27,137,447.76
210302	Түлш, халаалт	15,018,695.60	27,126,155.53
210303	Цэвэр, бохир ус	11,671,055.00	10,358,273.71
2104	Хангамж, бараа материалын зардал	15,149,496.50	26,301,249.00
210401	Бичиг хэрэг	3,865,028.00	12,473,958.00
210402	Тээвэр, шатахуун	6,007,978.50	6,268,582.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684,200.00	953,870.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	902,920.00	70,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,689,370.00	6,534,439.00
2105	Нормативт зардал	108,285,943.14	79,496,204.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	950,420.00	1,020,437.60
210502	Хоол, хүнс	107,335,523.14	78,475,766.56
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,702,970.00	11,555,560.00
210604	Урсгал засвар	3,702,970.00	11,555,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,348,790.00	9,442,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,325,600.00	4,769,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	798,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	248,040.00	150,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	410,150.00	483,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,305,000.00	3,240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,885,668.56	184,115,019.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,769,100.00	5,741,141.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,094,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	138,116,568.56	171,278,977.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,093,056.89	54,445,996.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,051,542.00	53,062,177.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	69,901.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,469,530.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,750,859.00	45,342,647.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,230,782.00	4,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,041,514.89	1,383,819.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,041,514.89	1,383,819.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(35,280,029.02)	(103,558,254.16)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(35,280,029.02)	(103,558,254.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,739,273,300.00	1,996,109,335.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,739,273,300.00	1,996,109,335.96
1310	Улсын төсвөөс	1,738,133,300.00	1,976,594,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,738,133,300.00	1,976,594,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,140,000.00	19,514,635.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,563,727.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	6,585,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,140,000.00	4,365,910.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,696,480,300.00	1,952,045,335.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,696,480,300.00	1,952,045,335.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,514,581,744.11	1,852,298,969.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,229,004,951.16	1,512,100,500.00
210101	Үндсэн цалин	714,610,171.15	770,149,376.00
210102	Нэмэгдэл цалин	464,259,725.91	557,339,195.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,046,936.16	57,758,772.50
210104	Урамшуулал	44,088,117.94	126,853,156.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,864,800.00	189,480,500.00
210201	Тэтгэврийн даатгал	147,780,600.00	131,776,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,021,000.00	14,426,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,216,900.00	11,541,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,102,700.00	2,885,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,743,600.00	28,852,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,906,699.60	66,089,900.00
21301	Гэрэл, цахилгаан	11,216,949.00	32,452,598.76
21302	Түлш халаалт	15,018,695.60	23,279,027.53
210303	Цэвэр, бохир ус	11,671,055.00	10,358,273.71
2104	Хангамж, бараа материалын зардал	10,496,696.00	18,139,025.96
210401	Бичиг хэрэг	1,196,500.00	9,599,225.96
210402	Тээвэр, шатахуун	4,176,676.00	5,726,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684,200.00	953,870.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	902,920.00	70,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,436,400.00	1,788,800.00
2105	Нормативт зардал	29,430,820.00	39,408,314.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,723,220.00	1,176,314.00
210502	Хоол, хүнс	26,157,000.00	37,807,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,550,600.00	425,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,357,000.00	6,855,510.00
210604	Урсгал засвар	4,357,000.00	6,855,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,275,390.00	9,198,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2,325,600.00	4,769,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	798,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	248,040.00	150,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	410,150.00	239,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,231,600.00	3,240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,245,387.35	11,026,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,362,500.00	1,963,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,882,887.35	9,063,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,898,555.89	99,746,366.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,857,041.00	98,362,547.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,875,400.00	48,769,900.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,750,859.00	45,342,647.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,230,782.00	4,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,041,514.89	1,383,819.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,041,514.89	1,383,819.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	42,793,000.00	44,064,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	42,793,000.00	44,064,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,793,000.00	44,064,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	42,793,000.00	44,064,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	42,793,000.00	44,064,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,793,000.00	44,064,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(42,793,000.00)	(44,064,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	888,053,349.02	1,598,023,346.88	(346,879,970.54)	2,139,196,725.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	947,344.00	947,344.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,053,349.02	1,598,023,346.88	(345,932,626.54)	2,140,144,069.36
Тайлант үеийн үр дүн	-	-	(35,280,029.02)	(35,280,029.02)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	888,053,349.02	1,598,023,346.88	(381,212,655.56)	2,104,864,040.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,296,615.63	5,296,615.63
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,053,349.02	1,598,023,346.88	(375,916,039.93)	2,110,160,655.97
Тайлант үеийн үр дүн	-	-	(103,558,254.16)	(103,558,254.16)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	888,053,349.02	1,598,023,346.88	(479,474,294.09)	2,006,602,401.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,976,594,700.00	1,975,210,881.00	1,383,819.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,976,594,700.00	1,975,210,881.00	1,383,819.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,878,053,500.00	1,876,848,334.00	1,205,166.00	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,512,100,500.00	1,512,100,500.00	-	100.0
210101	Үндсэн цалин	821,84,600.00	770,149,376.00	51,693,224.00	93.7
210102	Нэмэгдэл цалин	554,768,600.00	557,339,195.00	(2,570,595.00)	100.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	57,758,772.50	(57,758,772.50)	-
210104	Урамшуулал	135,489,300.00	126,853,156.50	8,636,143.50	93.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,480,500.00	189,480,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	131,776,200.00	131,776,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	14,426,000.00	14,426,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ даатгал	11,541,000.00	11,541,000.00	-	100.0
21204	Ажилгүйдлийн даатгал	2,885,300.00	2,885,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	28,852,000.00	28,852,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,089,900.00	66,089,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	31,489,600.00	32,452,598.76	(602,998.76)	101.9
210302	Түлш, халаалт	23,663,000.00	23,279,027.00	383,972.47	98.4
210303	Цэвэр, бохир ус	10,577,300.00	10,358,273.71	219,026.29	97.3
2104	Хангамж, бараа материалын зардал	9,755,300.00	9,755,300.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	524,400.00	1,035,500.00	(511,100.00)	197.5
210402	Тээвэр, шатахуун	5,243,400.00	5,726,730.00	(483,330.00)	109.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1170,200.00	953,870.00	216,330.00	81.5
210404	Ном, хэвлэл	165,500.00	-	165,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	422,200.00	70,400.00	351,800.00	16.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,229,600.00	1,968,800.00	260,800.00	88.3
2105	Нормативт зардал	40,054,400.00	39,408,314.00	646,086.00	98.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,183,500.00	1,176,314.00	7,186.00	99.4
210502	Хоол, хүнс	37,807,000.00	37,807,000.00	-	100.0
210503	Нормын хувцас	1,063,900.00	425,000.00	638,900.00	39.9

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,873,600.00	46,873,600.00	-	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	43,884,000.00	43,884,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,989,600.00	2,989,600.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,757,500.00	9,198,420.00	559,080.00	94.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4,769,800.00	4,769,800.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	798,700.00	798,700.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	172,000.00	150,420.00	21,580.00	87.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,600.00	239,500.00	43,100.00	84.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	134,400.00	-	134,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	3,240,000.00	360,000.00	90.0
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	3,941,800.00	3,941,800.00	-	100.0
210901	Бараа, үйлчилгээний бусад зардал	1,963,800.00	1,963,800.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,978,000.00	1,978,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,541,200.00	98,362,547.00	178,653.00	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,541,200.00	98,362,547.00	178,553.00	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,769,900.00	48,769,900.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,521,200.00	45,342,647.00	178,553.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,250,100.00	4,250,000.00	100.00	99.9
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,976,594,700.00	1,975,210,881.00	1,383,819.00	99.9
31	Улсын төсвөөс санхүүжих	1,976,594,700.00	1,975,210,881.00	1,383,819.00	99.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,976,594,700.00	1,975,210,881.00	1,383,819.00	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	68	72	(4)	105.9
610001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
610002	Гүйцэтгэх ажилтан	55	45	10	81.8
610003	Үйлчлэх ажилтан	12	26	(14)	216.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	19,514,635.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	19,514,635.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	19,514,635.96
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,563,725.96
210401	Бичиг хэрэг	-	8,563,725.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,865,910.00
210604	Урсгал засвар	-	3,865,910.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,085,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,085,000.00
1	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	19,514,635.96
13	Тусламж, санхүүжилтийн орлого	-	19,514,635.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,514,635.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,563,725.96
131104	Дээд шатны төсвийн байгууллагын захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	6,585,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,365,910.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,360.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 44,360.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХОАТ-ын тайланд 12,222.2 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг дутуу тайлагнасан	1	12,222.2			1	12,222.2	1	12,222.2				
Нийт 16,568.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	16,568.2			1	16,568.2	1	16,568.2				
Хандив, тусламжаар хүлээн авсан 14,905.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 665.0 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох дансад бүртгээгүй тус тус залруулсан байна.	1	15,570.0			1	15,570.0	1	15,570.0				
Дүн	3	44,360.4			3	44,360.4	3	44,360.4				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 45,836.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,317.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 43,519.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн нэмэгдлийг тооцохдоо төрд ажилласан жилийн нэмэгдэл болон цалингийн зэрэглэлийг илүү тогтоож олгосон 1,696.0 мянган төгрөг, дутуу олгосон 621.1 мянган төгрөг байна.	1	2,317.1	1	2,317.1								
Анхан шатны бүрдэл дутуу /и-баримтгүй / 8,032.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	1	8,032.3					1	8,032.3				
Тайлант онд цалин нэмэгдлээс үүссэн нийгмийн даатгалын шимтгэл 3,745.0 мянган төгрөг, ХХОАТ-ын 31,742.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.	1	35,487.1					1	35,487.1				
Дүн	3	45,836.5	1	2,317.1			2	43,519.4				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 89,778.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 89,778.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 159 мэдээллийн мэдээлэхээс 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 8 гүйлгээний 89,778.8 мянган төгрөгийн мэдээллийг ил тод мэдээлээгүй байна.	1	89,778.8			1	89,778.8		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил								
Тус сургуулийн эзэмшилд бүртгэлтэй хүүхэд тээвэрлэдэг 2 автобусны улсын дугаарыг төрийн албаны дугаараар солиогүй байна.	1	-					1	-
Дүн	2	89,778.8	-	-	1	89,778.8	1	-